



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шинэ үндэс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгө оруулалтаар баригдсан конторын барилга, 397 м.кв газар эзэмших эрхийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу үндсэн хөрөнгөд бүртгэхийг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн албанд зөвшөөрсүгэй.

2. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 дугаар хавсралтад заасан дуусаагүй барилга /карказ/, биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1065 м.кв газар эзэмших эрхийг тус тус данснаас хасч, “Шинэ үндэс” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүлээлгэн өгөхийг зөвшөөрсүгэй.

3. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Амаржаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Үндсэн хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өчмийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 09 дугаар сарын 22- ны
өдрийн 457 дугаар тогтоолын 1-р хавсралт



ШИНЭ ҮНДЭС ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИАС
АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСЭД ШИЛЖИХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Байршил	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)
1	Конторын барилга	2019	Сэлэнгэ аймаг Алтанбулаг сум	1	207,727,344.00
2	Газар эзэмших эрх	2020		397 м2	4,764,000.00
					212,491,344.00
					/Хоёр зуун арван хоёр сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга гурван зуун дөчин дөрвөн/

Төрийн өчмийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 09 дугаар сарын 22- ны
өдрийн 49 дугаар тогтоолын 2-р хавсралт

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ДАНСНААС ХАСЧ, " ШИНЭ ҮНДЭС" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИД ХҮЛЭЭГЭЖ ӨГӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Байршил	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)
1	Конторын барилгын карказ	2009	Сэлэнгэ аймаг Алтанбулаг сум	1	264,851,498.00
2	Газар эзэмших эрх	2009		1065 м2	12,780,000.00
					277,631,498.00
					/Хоёр зуун далан долоон сая зургаан зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун ерэн найм/